

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА” НЭР ТОМЬЁОНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ

Ц.АЗБАЯР

ДХИС-ийн Удирдлагын академийн захирал, цагдаагийн хурандаа

Товч агуулга: Энэхүү илтгэлээр хууль сахиулагч, хууль сахиулах байгууллага гэсэн нэр томьёо ном бүтээл, эрдэм шинжилгээ, судалгаа болон хууль тогтоомжид хэрхэн тусгагдаж, судлагдсан байдалд дүн шинжилгээ хийж, хэрэглээг судлах, гадаад хэл, гадаад орны хууль сахиулах байгууллагын тогтолцоотой харьцуулж үзэх, асуудлыг тодорхойлоход чиглэсэн. Ингэснээр хууль сахиулагч, хууль сахиулах байгууллага нэр томьёоны агуулга тодорхой болж, онолын болон хэрэглээнд нэр мөр ойлгох, тодорхойлогдох боломж бүрдэнэ.

Түлхүүр үгс: Хууль сахиулах, хууль сахиулах байгууллага, хууль сахиулах үйл ажиллагаа, хууль сахиулагч

Оршил. Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.7-д Засгийн газар “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх” талаар тус тус заасан. Энэ нь иргэний эрх, эрх чөлөөг төрөөс хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах талаар хүлээсэн төрийн үүрэг мөн. Энэ үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомжид хууль сахиулах байгууллага, хууль сахиулагч гэсэн нэр томьёог өөр өөр хэрэглэн хуульчилсан, агуулга нь ойлгомжгүй байх зэрэг маргаантай, хийдэлтэй нөхцөл байдал өнөөдрийг хүртэл байсаар байна. Тиймээс “хууль сахиулах”-тай холбоотой нэр томьёог судалж, тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, нэр томьёоны агуулгыг тодорхойлох, хэрэглээг сайжруулах хэрэгцээ шаардлага байсаар байна. Иймээс энэхүү сэдвийг дараах үндэслэлээр судаллаа. Үүнд: 1. Эрх зүйн зохицуулалтын хувьд эргэлзээтэй байдлыг үүсгэж байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын 830 гаруй хуулийн 18 орчим хуульд “хууль сахиулах”-тай холбоотой нэр томьёог хэрэглэсэн байгаа ч өөр өөр агуулгаар хэрэглэсэн нь судалгаанаас ажиглагдаж байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн тайлбарт “хууль сахиулагч” гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд,

байгаль хамгаалагчийг ойлгоно”¹ гэж заасан. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д “төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчид, үйлчилгээ үзүүлэгчдийг сургаж, мэргэшүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах”² талаар тус тус заажээ. Энэхүү эрх зүйн зохицуулалтаас харахад хууль сахиулагч гэж хэн бэ? Цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр, төрийн тусгай хамгаалалтын байгууллагад хүүхдийн асуудал хариуцсан ажилтан ажиллаж тэр нь хууль сахиулагч уу? гэсэн асуулт гарч байна. 2. “Хууль сахиулах байгууллага” гэсэн нэр томьёоны талаар онолын судалгаанд нэгдсэн нэр мөр ойлголтод одоогоор хүрээгүй байна. Хууль зүйн шинжлэх ухааны ном бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудад “Хууль сахиулах байгууллага”, “хууль сахиулагч”, “хууль сахиулах үйл ажиллагаа” гэсэн нэр томьёог өргөн хэрэглэсэн байна. Тухайлбал, академич Ж.Амарсанаа “хууль сахиулах байгууллага ба шүүх эрх мэдэл” гэсэн нэр томьёог тайлбарласан. Ингэхдээ “хууль хяналтын байгууллага” гэсэн нэр томьёонд шүүмжлэлтэй хандсан бөгөөд хяналтын гэсэн тодотголтой тусгай байгууллага бол прокурорын хяналт, мэргэжлийн хяналтын байгууллагыг, хуулийн байгууллага гэж нэрлэдэг нь буруу хуулийн, дүрмийн, тогтоолын байгууллага гэж байхгүй хууль сахиулах байгууллага гэж

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль.2017., <https://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

² Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016., <https://legalinfo.mn/mn/detail?lawid=11710>

хэрэглэх ёстой³ гэжээ. Үүнээс гадна эрдэмтэн судлаач нар төрийн онол, төрийн удирдлага, эрх зүйн онол, захиргааны эрх зүй чиглэлээр өргөн хүрээнд судалснаас бус, тухайлан судалсан бүтээлгүй, ганц нэг эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьсан төдий хязгаарлагдаж тоймтой дорвитой судалгаа хийгээд хариулт өгсөн нь байхгүй байна. 3. Нэр томьёоны хэрэглээний хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс төрчдийн үг, өдөр тутмын амьдралд хууль хяналтын байгууллага, хууль шүүхийн байгууллага, хуулийн байгууллага, хүчний байгууллага, төрийн тусгай байгууллага, төрийн цэргийн байгууллага, хууль сахиулах байгууллага, хууль сахиулагч, хууль сахиулах үйл ажиллагаа гэсэн нэршлүүд хэрэглэгдсээр байна.

Тиймээс хууль сахиулах байгууллага, хууль сахиулагч гэсэн нэр томьёог зөв, оновчтой байдлаар тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль сахиулагчдын эрх, үүргийг оновчтой тусгах, хуулийн хийдлийг засаж, сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Илтгэлийг бичихдээ хууль тогтоомж, холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах, бэлтгэх, мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, түүхчилсэн, нэр томьёог тайлбарлах, харьцуулан судлах, хэл шинжлэлийн аргыг ашиглан судалсан болно.

Нэг. Монгол Улсын хуулиудад “хууль сахиулах”-тай холбоотой нэр томьёог хэрэглэсэн байдалд хийсэн судалгаа

Монгол Улсад өнөөдрийн байдлаар 830 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээр хуулиудыг судалж үзэхэд хууль тогтоомжид “хууль сахиулах үйл ажиллагаа”, “хууль сахиулах байгууллага”-ийн талаар албан ёсны тодорхойлолт, жагсаалт байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан нийт 18 хуульд “хууль сахиулагч” болон “хууль сахиулах байгууллага” гэсэн нэр томьёог хэрэглэсэн боловч хууль сахиулах байгууллагад ямар байгууллагыг хамааруулж авч үзэх, хууль сахиулагч гэдэгт нийт ажиллаж байгаа алба хаагчдыг хамааруулж үзэх эсэх нь эргэлзээтэй байна. Тухайлбал, өмнө дурдсан Монгол Улсын эрүүгийн хуульд заасан “хууль сахиулагч” гэдэгт хамааруулсан эрх бүхий этгээдүүдийг ойлгох уу?⁴ гэсэн асуулт гарч “хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд” нь хэн болох нь ойлгомжгүй байна. Мөн 21.1 дүгээр зүйл “нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах”, 21.5 дугаар зүйл “гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх” гэмт хэргийн субъект хууль сахиулагч байхаар тогтоож өгсөн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад Тагнуулын байгууллага, Авлигатай тэмцэх байгууллага, Цагдаагийн байгууллага явуулна”, мөн хуулийн 6.2-т “мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар энэ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулна⁵ гэж тус тус заасан. Эндээс харахад хууль сахиулах байгууллагад энэ гурван байгууллага ба хууль сахиулагчид хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий албан тушаалтныг хамруулахаар ойлгогдож байна.

Дээрх хуулиас гадна тухайлбал, Иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “эцэг, эх буюу хууль ёсны хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхдийг Монгол Улсын хилээр авч гарах тохиолдолд хууль сахиулах байгууллага хяналт тавьж, хүүхэд хамгаалах байгууллагад

³Ж.Амарсанаа. Хууль зүйн нэр томьёоны булан.Хууль дээдлэх ёс., УБ хот. 2019. Дугаар 1. 137 дах тал

⁴ Монгол Улсын Эрүүгийн хууль.2017., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634>

⁵ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

мэдэгдэнэ”⁶, Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д “төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох”⁷, Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Зэвсэгт хүчин, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллага нь”⁸, “**Алсын хараа-2050**” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын **2021-2030** онд хэрэгжүүлэх арга хэмжээнд “Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохион

байгуулалт, үүрэг гүйцэтгэх чадавхыг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ”⁹, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” зарлигийн 4 дэх задтайд “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгох эрхийг **гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагад** харьяалуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох”¹⁰ хууль тогтоогч, Ерөнхийлөнчийн институт хэрэглэсэн боловч харьяалах ямар байгууллагыг тогтоосон нь тодорхойгүй хэвээр байна.

Хүснэгт 1. “Хууль сахиулах”-тай холбоотой нэр томъёоны хуульд туссан байдал

№	Хуулийн нэр	Туссан нэр томъёо
1	Галт зэвсгийн албан татварын тухай	Хууль сахиулах албаны
2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	Хууль сахиулах байгууллага, хууль сахиулах бусад байгууллага, хууль сахиулах үйл ажиллагаандаа
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай	Хууль сахиулах байгууллага
4	Зөрчлийн тухай	Хууль сахиулагч
5	Монгол Улсын Хилийн тухай	Хууль сахиулах байгууллага
6	Хүүхэд хамгааллын тухай	Хууль сахиулагч, хууль сахиулах байгууллага, цагдаагийн болон бусад хууль сахиулах байгууллага
7	Цэргийн албаны тухай	Хууль сахиулах байгууллагад
8	Эрүүл ахуйн тухай	Хууль сахиулах бүх шатны байгууллага
9	Эрүүл мэндийн тухай	Хууль сахиулах албаны
10	Төрийн болон албаны нууцын тухай хууль	Хууль сахиулах байгууллага, хууль сахиулах ажлын хүрээнд
11	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль сахиулагчийг бэлтгэх

⁶ Монгол Улсын Иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль. 1993., <https://legalinfo.mn/>

⁷ Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль. 2019., <https://legalinfo.mn/>

⁸ Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль. 2017., <https://legalinfo.mn/mn/>

⁹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>

¹⁰ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр зарлиг., <https://legalinfo.mn/mn/>

Хүснэгтэд харуулсан 11 хуулиас гадна 8 хуульд тус нэр томьёог хэрэглэсэн байна. Үүний дүнд эрдэмтэн судлаач, төрийн албан хаагч, хууль тогтоогч нарын дунд тасралтгүй маргаан үргэлжилж ямар байгууллагуудыг хууль сахиулах байгууллагуудад хамаатуулах төрийн төвшинд ч, шинжлэх ухааны төвшинд ч, боловсролын салбарт ч нэгдсэн ойлголт байхгүй байгаа нь Хууль зүй, дотоод хэргийн яамны Дотоод хэргийн их сургуулийн нэрийг Хууль сахиулахын их сургууль гэж нэрлэн буцаагаад Дотоод хэргийн их сургууль¹ болгож өөрчилж байгаагаас харагдана.

Дээр судалсан хуулийн зүйл заалтын эх бичвэрийн агуулгаас харвал хууль сахиулах байгууллага гэдэг нэр томьёог хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн гүйцэтгэх засаглалын байгууллагуудыг гэж ойлгож, дүгнэж болох боловч хууль сахиулах үйл ажиллагаа гэдгийг тодорхойлсон хэм хэмжээ алга байна. Нөгөөтээгүүр Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн тайлбар, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасан байгууллагуудын хэрэгжүүлж буй бүхий үйл ажиллагааг ойлгох эсхүл зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх, хянан шийдвэрлэх ажиллагааг ойлгох уу гэсэн асуулт үсч хууль сахиулах үйл ажиллагааны хамрах хүрээ тодорхойгүйгээс яг энэ байгууллагаад гээд шууд заах боломжгүй байна.

Нөгөөтэйгүүр хууль сахиулагч гэсэн нэр томьёог сүүлийн үед хэрэглэж байна уу гээд түүхэн талаас нь судлан үзвэл БНМАУ-ын 1940 онд баталсан Үндсэн хуулийн 57 дугар зүйлд “Бүх яамд

ба төв орон нутгийн албан байгууллагууд хийгээд тэдгээрийн харьяат газрууд, мөн албан тушаалын хүмүүс ба ард нийтээс хууль цаазыг нарийнаар биелүүлж байгаа явдлыг байцаан хянах туйлын үүргийг улсын прокурор /хууль сахигч/ хүлээнэ”² гэж зааж байсан байна.

Мөн 1990-ээд онд Монгол Улсын Үндсэн хуулийн талаар яригдаж байх үед Их засаг хуулийн төсөл боловсруулж байсан ба Тавдугаар бүлэг Бүгд найрамдах Монгол Улсын Их засаг хуулийг сахиулах баталгаа гэсэн бүлэгт 64 зүйлийн 1-д “Их засаг хуулийн цэц бол Их засаг хуулийн биелэлтэд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, их засаг хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”³, төслийн 61-р зүйлд:

1. Хууль сахиулагч нь хэргийг мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд болон нийгэм, иргэдийн эрх, ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэн хамгаалах зорилгоор хуулийг нэг мөр сайн биелүүлж байгаад төрийн хяналт тавина.
2. Хууль сахиулагч нь шүүх хуралд төрийн өмнөөс яллах үүргийг гүйцэтгэнэ.
3. Улсын Ерөнхий хууль сахиулагчийг Монгол Улсын Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцсөнөөр 6 жилийн хугацаагаар томилно.
4. Хууль сахиулах газрын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим журмыг хуулиар тогтооно”⁴ гэж прокурорыг хууль

¹ Засгийн Газрын 2011 оны 243 дугаар тогтоол “Дотоод хэргийн их сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, Засгийн газрын 2012 оны 87 дугаар тогтоол “Дотоод хэргийн их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай”, Засгийн Газрын 2019 оны 152 дугаар тогтоол “Хууль сахиулахын их сургуулийн өөрчлөн зохион байгуулах тухай”., <https://legalinfo.mn/mn/>

² <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1940.html>

³Бүгд найрамдах Монгол Улсын их засаг хууль., Анхдугаар хэлэлцүүлгээр АИХ-аас баталсан өөрчлөлтийг тусгасан төсөл, 36-37-р тал

⁴Монгол Улсын Их цааз. / Үндсэн хууль/Төсөл. Засгийн газрын хэвлэх үйлдвэр,. 1991 оны 6 сарын 11 өдөр.

сахигч, хууль сахиулагч, прокурорын байгууллагыг хууль сахиулах газар нэгж төсөлд тусган хэрэглэх оролдлого хийж байжээ.

Үүнээс харвал прокурорын үйл ажиллагааг хууль сахиулах ойлголтод хамааруулан ойлгож, түүхэн цаг үеүдэд авч үзэж энэ ойлголтын утга агуулга мөн чанараараа хувьсан өөрчлөгдөж байжээ.

Хоёр. Нэр томьёоны талаарх эрдэм, шинжилгээ, судалгааны ажлын тойм

Энэ чиглэлээр эрдэмтэн судлаач нарын бүтээлд туссаныг тоймловол зарим эрдэмтэд “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах бусад байгууллагуудад шүүх, прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллага, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага, өмгөөлөх байгууллага, нотариатын байгууллагыг”⁵, зарим нь “Цагдаагийн алба, шүүхийн шинжилгээний алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, тахрын алба, онцгой байдлын алба, авлигатай тэмцэх алба, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, хил хамгаалах алба, тагнуулын алба”, “ТЕГ-ын Сөрөх тагнуулын нэгжүүд, Цагдаа, шүүхийн шийдвэр, авлигтай тэмцэх байгууллага”⁶-уудыг гэж заасан. Мөн “хууль ёс, эрх зүйн дэг журмыг хамгаалах, хүний эрх ба эрх чөлөөг хамгаалах, гэмт явдалтай тэмцэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага, хууль сахиулах байгууллагад шүүх, үндсэн хуулийн шүүх, прокурорын байгууллага, дотоод хэргийн асуудал эрхэлсэн байгууллага, улсын аюулгүй байдлын алба, улсын хяналт шалгалтын байгууллага, гаалийн хяналт

шалгалт, хууль зүйн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага зэрэг олон байгууллагуудыг хамааруулан судалжээ. Зарим судлаачид өргөн утгаараа төрийн бус институт багтах ба үүнд: өмгөөлөх байгууллага, нотариатын байгууллага, хөндлөнгийн шүүх зэрэг⁷ оруулан тайлбарласан байна. Эдгээр бүтээлүүдийг харьцуулан үзвэл энэ нэр томьёо нь судлаачид аль өнцгөөс нь тайлбарлаж байгаагаас хамааран өөрөөр тайлбарлажээ. Эндээс харахад хууль сахиулах байгууллагын тухай нэгдмэл ойлголт болон төрийн аль нэг байгууллагыг хууль сахиулах байгууллагад хамаатуулах эсэх нь тулгамдсан асуудал хэвээр байна.

Гурав. Нэр томьёоны хэрэглээ, тайлбар, гадаад хэлний орчуулгын агуулгыг харьцуулан судлах нь

Монгол хэл зүйн талаас нь тайлбарлавал “Сахиу-Дагаж мөрдөх, журамлах”⁸, хууль сахиу-(хууль ёсыг дагаж мөрдөх)⁹ гэж монгол хэлний орчин үеийн тайлбар тольд дурджээ. Харин эрх зүйн онол талаас үзвээс эрх зүйн хэм хэмжээг сахиу гэдэг нь зөвхөн хориглосон хэм хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой. Заримдаа эрх зүйн хэм хэмжээг сахиу нь үүрэг болгосон хэм хэмжээг сахиутай холбож тайлбарладаг¹⁰.

Аль ч тохиолдолд утга нь хориглосон үйлдлийг гүйцэтгэхээс түдгэлзэх, тэвчихтэй холбоотой. Эрх зүйн хэрэгжилтийн энэ хэлбэрийн нийгмийн зориулалт нь нийгэм, төрөөс гадна хувь бие хүнд ямар нэгэн хор хохирол учруулах үйлдэл үйлдэхээс сэргийлэх, гаргуулахгүй байхад чиглэнэ.

⁵ С.Жанцан. Шүүх эрх мэдэл болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо. УБ., 2005. 16 дах тал

⁶ М.Цогтоо, Ц.Очгэрэл, С.Хүдэрчулуун. Гүйцэтгэх ажлын удирдахуй.УБ., 2021.

⁷ С.Нарангэрэл. Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг. УБ., 2015, дөрөв дэх хэвлэлт <https://mn.wiktionary.org/wiki>

⁸<https://mongoltoli.mn/dictionary/detail/77351>

⁹<https://mongoltoli.mn/dictionary/detail/77321>

¹⁰Дворняк А.И. Правовое регулирование реализации права. Лекция. М., 1999

Үүргийг сахих нь идэвхтэй бус идэвхгүй шинжтэй. Эрх зүйн субъект идэвхтэй үйлдэл хийх замаар биш хуулиар хориглосон үйлдлийг хийхээс түдгэлзсэнээр эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх энэ хэлбэр хангагдана.

Улмаар монгол хэлний орчин үеийн тайлбар тольд хандвал “сахиулах-Дагаж мөрдүүлэх: сахилга журмыг сахиулах (дүрэм журмыг дагаж мөрдүүлэх)¹¹ гэсэн утгаар тайлбарлажээ. Эндээс үзвэл “Хууль сахиулах” гэдэг нь хууль ёсыг дагаж мөрдүүлэх бусдаар гүйцэтгүүлэх үйл болох нь харагдаж байна.

Академич С.Нарангэрэлийн “хууль зүйн англи-монгол эх толь”-д Law-эрх зүй, хууль, хууль тогтоомж, нийтийн эрх зүй, шүүх, шүүх ажиллагаа, шүүхийн практик, шүүхийн практик, шүүхийн процедур, шүүх цааз, хуульчид, Law enforcement-эрх зүйн албадлага, эрх зүй хэрэглэх, хууль хэрэглэх, цагдаагаас эрх зүй хэрэглэх, эргүүлийн цагдаа¹² гэсэн байна.

Орос хэл дээр “правоохранительная деятельность” гэж нэрлэх ба шууд орчуулбал “эрх зүйг /эрхийг/ хамгаалах үйл ажиллагаа гэж орчуулагдах бөгөөд эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон таслан зогсооход чиглэсэн өөр өөрийн тогтоосон бүрэн эрхийн хүрээнд албадлагын арга хэмжээг хэрэглэхэд чиглэсэн, иргэний нийгмийн байгууллалын тусгай институтын тусламжтайгаар зөрчигдсөн эрх ба нийгмийн шударга ёсыг сэргээхэд чиглэсэн төрийн зарим байгууллагуудын

үйл ажиллагаагаар илрэн гарах төрийн чиг үүрэг гэж¹³ авч үзээд эрх зүйг хамгаалах байгууллагуудад бүх шатны шүүх, прокурор, мөрдөх хороо, ДХЯ, Хууль зүйн яам, ХЯШГА, ХАБА, ХХА, ГТА, Үндэсний гварди, Холбооны татварын алба, Нотариат, Хүний эрхийн байгууллага, өмгөөлөл, хувийн хамгаалалтын алба, хувийн мөрдөх товчоо, хүний эрхийн хамгаалах байгууллагууд зэргийг хамаатуулсан байна¹⁴. Харин С.Нарангэрэл правоохранительный гэдгийг эрх зүй сахиулах, хууль сахиулах¹⁵ гэж орчуулан хэрэглэжээ.

Англи хэл дээр “law enforcement” буюу “хууль сахиулах”¹⁶ гэдэг нь “нийтийн дэг журмыг сахих болон хуулийг сахиулах, гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөх болон гэмт этгээдийг баривчлах үйл ажиллагааг хариуцсан байгууллагуудын үйл ажиллагааны ерөнхий нэр¹⁷, “enforcer” гэдэг нь цаанаа албадлагын шинжийг агуулсан хэрэгжүүлэх, сахиулах, хэрэглэх, шаардах, “law enforcement agency” буюу “хууль сахиулах байгууллага” гэдэг нь сэжигтнийг баривчлах болон гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөх үндсэн чиг үүрэгтэй холбооны, мужийн, орон нутгийн байгууллага, түүний нэгж хэсгийг хэлнэ гэж тайлбарласан байна¹⁸.

Оросын эрдэмтний бичиж хэвлүүлсэн “Шинэ англи-орос болон орос-англи хууль зүйн толь”¹⁹ “Law enforcement-правоприменение, применение закона, правоохранительный” буюу эрх

¹¹<https://mongoltoli.mn/dictionary/detail/77321>

¹²С.Нарангэрэл. Хууль зүйн англи-монгол эх толь. УБ., 2012. 334 дах тал

¹³Ю.А.Цветков. Правоохранительные органы. М., 2020. С 8.

¹⁴Ю.А.Цветков. Правоохранительные органы. М., 2020. С 11

¹⁵С.Нарангэрэл. Орчин үеийн орос-монгол хууль зүйн тайлбар толь. УБ/М., 2017. 199 дах тал

¹⁶ Oxford Monsudar English-Mongolian, Mongolian-English Pocket Dictionary. First Edition. Monsudar Publishing. 2008., page 149

¹⁷ The Dictionary of Criminal justice. Sixth Edition. Dushkin/McGraw-Hill. 2003., page 206

¹⁸ The Dictionary of Criminal justice. Sixth Edition. Dushkin/McGraw-Hill. 2003., page 206

¹⁹Ю.Д.Ильин. Новый англо-русский и русско-английский юридический словарь. М., 2009. С 126

зүйг хэрэглэх, хууль хэрэглэх, эрх зүйг хамгаалах гэж тайлбарласан байна. Мөн Law enforcement officer-блүститель закона, страж порядка²⁰/хууль сахиулагч, журмыг хамгаалагч/ гэжээ.

Иймээс цаашид “law enforcement” болон “правоохранительный” гэдэг англи, орос хэлний нэр томъёог орчуулахдаа “хууль сахиулах” гэж орчуулан хэрэглэж болохоор харагдаж байна.

Гадаад зарим орны хууль сахиулах байгууллагын тогтолцоог авч үзвэл:

- АНУ-д хууль сахиулах байгууллагын тогтолцоонд Холбооны мөрдөх товчоо, Хар тамхитай тэмцэх газар, тэсэрч дэлбэрэх болон галт зэвсэг, тамхи, согтууруулах ундаа хариуцсан товчоо, Нууц алба, Холбооны маршалын алба, АНУ-ын цагаачлалын болон гаалийн алба, Холбооны шоронгийн товчоо, АНУ-ын эргийн хамгаалалт, Гаалийн болон Хилийн хамгаалалтын алба болон бусад²¹ байгууллагууд ордог өөрийн өвөрмөц онцлог тогтолцоотой улс юм.

-Туркийн хууль сахиулах байгууллагуудын ихэнх нь Бүгд найрамдах Турк Улсын Дотоод хэргийн яаманд харьяалагддаг. Турк улсад Эрүүгийн хууль сахиулах журмын 4 дүгээр зүйлд зааснаар: Аюулгүй байдлын ерөнхий газрын харьяа Цагдаагийн газар, Жандармерийн ерөнхий командлалын харьяа Жандармерийн ангиуд, Эргийн хамгаалалтын командлалд харьяалагддаг эргийн станцууд болон завины байгууллагууд, хөвөгч застав, ГЕГ-ын харьяа гаалийн харуул, хууль бусаар хил нэвтрүүлэх, тагнуулын газар, хэлтэс гэсэн хууль сахиулах байгууллагууд байна.

-Бүгд Найрамдах Киргиз Улсад хууль сахиулах байгууллагад дотоод

хэргийн салбарын байгууллагууд, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх салбарын байгууллагууд, татварын албаны байгууллагууд, үндэстний аюулгүй байдлын салбарын байгууллагууд, хууль сахиулах зарим чиг үүргийг хэрэгжүүлдэг хуулийн гүйцэтгэлд хяналт тавих салбарын байгууллагууд²² ордог юм байна.

-Бүгд Найрамдах Казахстан Улсад хууль сахиулах байгууллагуудад прокурорын байгууллага, дотоод хэргийн байгууллагууд, гал түймэртэй тэмцэх улсын алба, авлигатай тэмцэх алба, эдийн засгийн хэргийг мөрдөн шалгах алба²³ багтаж байна.

Улс орон бүрийн хууль сахиулах тогтолцоо өөр өөр байгаа нь тухайн улсын төрийн байгууламжийн хэлбэр, туулж ирсэн түүх, уламжлал, эрх зүйн тогтолцоо, тухайн үед дэвшүүлж буй зорилго, нийгэмд давамгайлсан үзэл санаанаас хамааралтай гэдэг нь харагдаж байна.

Дүгнэлт

Сүүлийн 30 жилийн хугацаанд нийгмийн нэг тогтолцооноос шилжих үйл явц өрнөж байгаа энэ цаг үед уламжлал болсон маш олон ойлголт, тогтсон нэр томъёо өөрчлөгдөхөөс өөр аргагүй юм. Орчин цагийн шинэ нэр томъёо хууль зүйн шинжлэх ухааны хэрэглээнд орж, хэвшсэн ч зарим нэр томъёо одоо хүртэл маргаантай хэвээр байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан байгуулах эрхэм зорилго тодорхойлсон тул төрийн алба, төрийн үйлчилгээ хүндээ иргэндээ хандсан, түүний эрх, эрх чөлөөг хамгаалах сэргээн эдлүүлэхэд л гагцхүү чиглэх ёстой гэсэн суурь үзэл баримтлалыг баримтлан хууль сахиулах,

²⁰Мөн тэнд

²¹ <https://ru.wikipedia.org/wiki/>

²² <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/111956>

²³ <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/111956>

хууль сахиулагч, хууль сахиулах байгууллага гэсэн нэр томъёог тодорхойлж, ямар байгууллага ямар шалгуураар багтах, ямар албан тушаалтан ямар эрх, үүрэг эдлэхвэ гэдгийг нэг мөр болгож, хуульчлан тогтоох нь зүйтэй байна.

Хууль сахиулах байгууллага нь олон талт үйл ажиллагаа явуулдаг гүйцэтгэх засаглалын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах, нийгмийн дэг журмыг бэхжүүлэхэд чиглэсэн, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үүрэг бүхий, хууль зүйн нөлөөллийн хэрэгсэл албадлага хэрэглэх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмын дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг төрийн байгууллагыг хэлж болно гэж судлаачийн хувьд шалгуур категориЙг тодорхойлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд хүнлэг, энэрэнгүй байх, хуулийг дээдлэх, төр хүндээ хандах хандлага хуульчлагдсан. Тиймээсхууль сахиулах үйл ажиллагааны агуулга энэхүү үзэл баримтлал, үзэл санаад үндэслэж, агуулга, мөн чанар нь тодорхойлогдож бусад хууль тогтоомжид тусгагдах нь зүйн хэрэг юм. Тиймээс хууль сахиулагчийг хүний эрхийн хязгаар дээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг гэж хэлж болох ба хүний эрхийн зөрчил гараагүй тохиолдолд хууль сахиулагч оролцохгүй байх хүрээ хязгаар тодорхойлогдож байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Монгол Улсын Эрүүгийн хууль. 2017., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634>
- Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль. 2017., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>
- Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016.,

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11710>

- Монгол Улсын Иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль. 1993., <https://legalinfo.mn/>
- Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль. 2019., <https://legalinfo.mn/>
- Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль. 2017., <https://legalinfo.mn/mn/>
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр зарлиг., <https://legalinfo.mn/mn/>
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>
- Засгийн Газрын 2011 оны 243 дугаар тогтоол “Дотоод хэргийн их сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, Засгийн газрын 2012 оны 87 дугаар тогтоол “Дотоод хэргийн их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай”, Засгийн Газрын 2019 оны 152 дугаар тогтоол “Хууль сахиулахын их сургуулийн өөрчлөн зохион байгуулах тухай”., <https://legalinfo.mn/mn/>
- БНМАУ-ын Үндсэн хууль. 1940., <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1940.html>
- Бүгд найрамдах Монгол Улсын Их засаг хууль., Анхдугаар хэлэлцүүлгээр АИХ-аас баталсан өөрчлөлтийг тусгасан төсөл, УБ.,1991.
- Монгол Улсын их цааз. / Үндсэн хууль/Төсөл. Засгийн газрын хэвлэх үйлдвэр,. 1991 оны 6 сарын 11 өдөр.
- Амарсанаа Ж. Хууль зүйн нэр томъёоны булан.Хууль дээдлэх ёс., УБ хот. 2019.№1.

- Жанцан С. Шүүх эрх мэдэл болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо. УБ., 2005.
- Нарангэрэл С. Хууль зүйн англи-монгол эх толь. УБ., 2012.
- Нарангэрэл С. Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг. УБ., 2015, дөрөв дэх хэвлэлт <https://mn.wiktionary.org/wiki>
- Нарангэрэл С. Орчин үеийн орос-монгол хууль зүйн тайлбар толь. УБ/М., 2017.
- Цогтоо М., Очгэрэл Ц., Хүдэрчулуун С. Гүйцэтгэх ажлын удирдахуй. УБ., 2021.
- <https://mongoltoli.mn/dictionary/detail/77351>
- <https://mongoltoli.mn/dictionary/detail/77321>
- Дворняк А.И. Правовое регулирование реализации права. Лекция. М., 1999
- <https://mongoltoli.mn/dictionary/detail/77321>
- Ильин Ю.Д. Новый англо-русский и русско-английский юридический словарь. М., 2009.
- Цветков Ю.А. Правоохранительные органы. М., 2020.
- Oxford Monsudar English-Mongolian, Mongolian-English Pocket Dictionary. First Edition. Monsudar Publishing. 2008., page 149
- The Dictionary of Criminal justice. Sixth Edition. Dushkin/McGraw-Hill. 2003., page 206
- The Dictionary of Criminal justice. Sixth Edition. Dushkin/McGraw-Hill. 2003., page 206
- <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/111956>
- <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/111956>